



ТҮШИГ СУМЫН МОНГОЛ  
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-09-30 № 027-2020/04-НА-14  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Түшиг сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Түшиг сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

## Дүгнэлт

Түшиг сумын Монгол Ардын намын хорооны Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Түшиг сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...3..... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Түшиг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС  
ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ТҮШИГ СУМ  
2020 ОН**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ТҮШИГ НУТГИЙНХАА ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ**

Түшиг сум иргэдээ дээдэлж, өрхөө дэмжих, эдийн засгийн өсөлтөд тулгуурласан хүн төвтэй бодлого хэрэгжүүлснээр **ИРЭЭДҮЙ НЬ ГЭРЭЛТЭЙ - ИРГЭД НЬ ЖАРГАЛТАЙ СУМ** болно.

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗОРИЛТУУД:**

1. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
2. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО
4. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

**НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 1.1 Сум хөгжүүлэх сангийн зээл олголтыг нэмэгдүүлж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.
- 1.2 Багш нарын чадавхыг сайжруулах чиглэлээр гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд тогтмол хамруулж, шаардлагатай мэргэжлийн багшийг орон нутагт ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.
- 1.3 Сумын иргэдийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.4 Ахмад настнуудыг хөдөлмөр эрхлэх боломжоор хангах талаар гаргасан санал, санаачилгыг дэмжинэ.
- 1.5 Ахмад настнуудыг амралт сувилалд амраах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 1.6 Гэр бүл, хүүхэд, залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин бий болгоход зориулсан цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбайн тохижилтыг сайжруулж, спорт заал барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 1.7 Хүүхэд, залуусыг урлаг, спортоор тууштай хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, бүх талаар дэмжинэ.
- 1.8 Өрх толгойлсон эх, эцэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан санал, санаачилгыг дэмжин, хамтарч ажиллана.

**ХОЁР: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- 2.1 Сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр гаргасан өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санал, санаачилгыг дэмжинэ.
- 2.2 Шаамар-Зэлтэр чиглэлийн хатуу хучилттай замыг ашиглалтад оруулах, бодит ажил болгоход эрх бүхий бусад байгууллагуудтай хамтарч ажиллана.



- 2.3 Зэлтэр хилийн боомтыг нээх, нүүрсийг эргэлтэд оруулж тээвэрлэх талаар эдийн засгийн тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 2.4 Сумын төвийн дулааны шугамыг шинэчлэн засварлах, өргөтгөх, уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлж, айл өрхүүдийг дулаан, цэвэр ус, бохирын шугамд холбох ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийнэ.
- 2.5 Залуу гэр бүлийг орчин үеийн фермийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.6 Тэжээлийн ургамал тариалах, дарш бэлтгэх чиглэлээр гаргасан малчдын санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 2.7 Нутагшсан Халимаг үүлдрийн үхрийг үржүүлэх талаар онцгойлон анхаарч ажиллана.
- 2.8 Малын гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр гаргасан иргэдийн санаачилгыг дэмжинэ.
- 2.9 Өвөлжөө, хаваржаа шинээр барих, засах малчдад мод, модон материал нийлүүлэх аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.10 Бэлчээр, хадлангийн газар ашиглах талаар иргэд болон аж ахуйн нэгж байгууллагын хооронд үүссэн маргааныг хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.
- 2.11 Стандартад нийцсэн 200 тонноос доошгүй багтаамжтай хүнсний ногоо хадгалах зорийг аж ахуйн нэгж, байгууллагуудын дэмжлэгээр барих ажлыг зохион байгуулна.
- 2.12 Ногоо тариалагчдын бүтээгдэхүүний борлуулалтыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, сүлжээ дэлгүүр борлуулалтын цэгүүдтэй холбон, зуучлах ажлыг зохион байгуулна.
- 2.13 Нүүрсний уурхайг түшиглэн шахмал болон сайжруулсан түлш үйлдвэрлэх, зах зээлд нийлүүлэх боломжийг тооцоолол хийж судлан, энэ талаар гаргасан иргэдийн санал санаачилга, төслийг дэмжинэ.
- 2.14 Өндөр хүчдэлийн 35 квт-ийн цахилгааны шугамд холбох ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтарч хэрэгжүүлнэ.

### **ГУРАВ: БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО**

- 3.1 Малын үүлдэр угсааг сайжруулах, адуу, ямаан сүргийн зохистой хэмжээг бүрдүүлэхэд анхаарч, бэлчээр талхлагдахаас сэргийлэх ажлуудыг үе шаттай авч хэрэгжүүлнэ.
- 3.2 Бэлчээрийн сэлгээг зөв зохион байгуулах, алслагдсан бэлчээрийг ашиглах замаар жил дараалан ашиглаж байгаа бэлчээрийг амраах, сэргээх ажлыг зохион байгуулж, хэвшүүлнэ.
- 3.3 Тариалангийн талбайн хөрсний элэгдэл, үржил шим алдагдлаас хамгаалах ажлыг аж ахуйн нэгж байгууллагууд хэрхэн шийдвэрлэж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулна.
- 3.4 Тариалангийн талбай тэлэх, бэлчээр сүйтгэх зэрэг хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчил гаргасан аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.
- 3.5 Уулын ам хашиж ан амьтан сэлгэн нүүдэллэх замыг хаасан, мал амьтад ухсан нүх шуудуунд унах, өргөст торонд орооцолдон гэмтэх зэрэг үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авна.

- 3.6 Уул уурхайн зөв зохистой ашиглалтад хяналт тавьж, зохих стандарт, дүрэм журмыг мөрдөж ажиллаагүй, зөрчил дутагдал удаа дараа гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээг авч ажиллана.
- 3.7 Үерийн даланг сэргээн засварлаж, үер усны аюулаас сэргийлэх арга хэмжээ авна.
- 3.8 Байгалийн үзэсгэлэн бүхий тодорхой газруудыг тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна.
- 3.9 Байгаль орчинд ээлтэй эко бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар гаргасан санал санаачилгыг дэмжиж ажиллана.

### ДӨРӨВ: ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 Ёс зүйтэй, хүнд сурталгүй, соёлтой, эерэг хандлагыг төрийн албанд төлөвшүүлнэ.
- 4.2 Төрийн албан хаагчид танил талдаа төсөл хөтөлбөр, сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдахад давуу эрх олгоход нөлөөлдөг байдал болон намын харьяаллаар иргэдэд ялгавартай ханддаг байдлыг зогсооно.
- 4.3 Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэлтэй иргэд цахимаар болон биечлэн танилцах нөхцөл боломж бүрдүүлнэ.
- 4.4 Орон нутаг, хил хамгаалах байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулна.

ТҮШИГ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

